МЭДЭЭ · 2025 оны 3-р сарын 21

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД “ШУДАРГА ЁС” СЭДВЭЭР МЭДЭЭЛЭЛ ӨГЧЭЭ



Налайх, Багахангай дүүргийн прокурорын газраас дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын “**Justice club”**-ын сурагчдад прокурорын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар болон “Шударга ёс” сэдвээр мэдээлэл өгч, ярилцсан байна.



Налайх дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санаачилгаар дүүргийн ерөнхий боловсролын 5 сургуульд “justice club” байгуулагдсан бөгөөд энэхүү клуб нь шударга ёсны үзэл баримтлалд тулгуурлан сурагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлан таниулах, цаашид хуульч мэргэжлийг сонгон суралцах хүүхдүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгох зорилготой юм.



Цаашид тус клубын сурагчдад Налайх, Багахангай дүүргийн прокурорын газраас хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалт, арга хэмжээг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөжээ.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1108